Төсөл

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2017 оны ... дугаар сарын ...-ны өдөр | Дугаар ..... | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт заасныгүндэслэн ТУШААХ нь:

1. “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлыг тооцох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгаллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга /С.Тунгалагтамир/, Нийгмийн хамгаллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Б.Ундрал/ нарт даалгасугай.

4.Энэ журмыг 2017оны...дугаар сарын...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД Н.НОМТОЙБАЯР

Төсөл

Төсөл

Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын
2017 оны ... дугаар сарын ....-ны өдрийн
....дугаар тушаалын хавсралт

ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГ ХҮНД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫГ ТООЦОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журам нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг тооцохтой холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ” гэж хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэхийг;

1.2.2. “Түр хамгаалах байр” гэж хохирогчийг тодорхой хугацаагаар байрлуулан үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий стандарт хангасан газрыг;

1.2.3. “Хувьсах зардал” гэж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ өөрчлөгдөхөд нийт хэмжээ нь өөрчлөгддөг зардлыг.

ХОЁР. ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ

2.1 Түр хамгаалах байрны үйлчилгээ нь дараах төрөлтэй байна. Үүнд:

2.1.1 Аюулгүй байдлын хамгаалалт;
2.1.2 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ;
2.1.3 Сэтгэл зүйн үйлчилгээ;
2.1.4 Нийгмийн ажлын үйлчилгээ;
2.1.5 Хүүхэд хамгааллын үйлчилгээ;
2.1.6 Эрх зүйн туслалцаа;
2.1.7 Холбон зуучлах үйлчилгээ;

2.4 Цагдаагийн алба хаагчын аюулын зэргийн үнэлгээ, хамтарсан багийн нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн үйлчлүүлэгчид үзүүлэх үйлчилгээний төрөл, хугацааг тодорхойлж, төлөвлөн хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГ ХҮНД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Төсөл

3.1 Түр хамгаалах байрны үйлчилгээний зардлыг тооцохдоо энэхүү аргачлалыг ашиглана.

3.2 Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хоногийн зардлын нийт хэмжээ нь тухайн үйлчлүүлэгчид үзүүлсэн үйлчилгээний төрөл, зардлын нийлбэрээр тодохойлогдоно.

3.3 Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд үйлчлүүлэгч давтан үйлчлүүлсэн тохиодолд журмын 3.2-т заасны дагуу тухай бүрт нь зардлыг тооцно.

3.4 Түр хамгаалах байрны үйлчилгээнд хамрагдах нэг үйлчлүүлэгчийн нэг хоногийн зардлыг тооцохдоо доорх үнийн тарифыг баримтлана. Энэ нь үйлчлүүлэгчийн (иргэн/хүүхэд)-ийн 1 хоногийн зардлын дээд хэмжээ.

№	Үйлчилгээний төрөл	Үнийн дүн
1.	Байр	2500
2.	Хоол хүнс	4000
3.	Ариун цэвэр	1000
4.	Аюулгүй байдлын хамгаалалт	2000
5.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	2200
6.	Сэтгэл зүйн үйлчилгээ	2500
7.	Нийгмийн ажлын үйлчилгээ	2500
8.	Эрх зүйн туслалцаа (зөвлөгөө)	3000
9.	Холбон зуучлах үйлчилгээ	2100
10.	Цалин (ажилтан)	3500
11.	Шимтгэл (11%)	385
	Нийт дүн	**25.685**

3.5 Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээг инфляцийн түвшинг харгалзан жил бүр шинэчлэн тогтооно.

ДӨРӨВ. ХОРИГЛОХ ЗҮЙЛ

4.1.Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд зорилтот бус үйлчлүүлэгч хамруулах, хуурамч бичиг баримт бүрдүүлэхийг хориглоно.

4.2. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно.

4.3. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний төсвийг олон нийтэд мэдээлэхдээ хувь хүний нууцыг задруулахыг хориглоно.